

# 2014 | Хагас жилийн тайлан

## ОРШИЛ

Монгол улсын “Улсын Их Хурал”-аас “ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг батлан гаргаж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах нэгдсэн зах зээлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш 1 жил гаруй хугацаа өнгөрөөд байна.

Хөдөө аж ахуйн биржийн эрхэм зорилго “Монголын хөдөө аж ахуйн салбарыг бодит үнэ ханш, оновчтой тогтолцоо бүхий салбар болгон төлөвшүүлэх”-д орших бөгөөд 2014 онд энэхүү эрхэм зорилгынхоо хүрээнд спот зах зээлийг өргөжүүлэх, биржээр арилжих бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэх, тэдгээрт суурилсан санхүүгийн үүсмэл хэрэгслийн туршилтын арилжааг эхлүүлэх, биржийн цахим арилжааны цогц системийг суурилуулах, зах зээлийн нийт оролцогчдыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014 оны эхний хагас жилийн байдлаар нийт 450.3 тэрбум төгрөгийн дүнтэй худалдах, худалдан авах гэрээ байгуулагдаж, төлбөр тооцоо журамд заасан хугацаандаа бүрэн хийгдэж дууслаа.

Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшхи хугацаанд баримталж байсан зарчмын дагуу 2014 оны эхний хагас жилд ч мөн биржийн бүтэц, зохион байгуулалт болон түүний үндсэн нэгжүүдийн чиг үүргийг оновчтой тогтоон, шаардлагатай хүний нөөцөөр бэхжүүлэх, үйл ажиллагааныхаа бүхий л хэлбэрийг журамлан хэвшүүлэх, мөн дотоод үйл ажиллагааны хүрээнд төлөвлөлт, тайлагналын нэгдсэн тогтолцоонд шилжих, биржийн үйл ажиллагааг хэвийн жигд явуулах нөхцөлийг бүрдүүлж, байгууллагаа олон нийтэд сурталчлан таниулах, биржийн гадаад, дотоод харилцааг өргөтгөхийн зэрэгцээ гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд “Санхүүгийн зохицуулах хороо” болон биржээс тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тавих хяналтыг тогтмолжуулж, тэдгээрийн үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд зөв зохистой, шударгаар явуулах чиг үүрэгтэйгээр ажилласан болно.

2013 оны жилийн эцсийн байдлаар биржийн гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтийг ханган, биржтэй гэрээ байгуулсан биржийн байнгын гишүүн 27 брокерын компани үйл ажиллагаа явуулж байсан бол 2014 оны эхний хагас жилийн байдлаар гишүүдийн тоо

нэмэгдэж, нийт 30 брокерын компани байнгын гишүүний гэрээ байгуулан ажиллаж байна. Түүнээс биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон гишүүний шалгуур үзүүлэлтэд заасны

дагуу нийт байнгын гишүүний гэрээний хугацааг сунгасан 15, шинээр биржийн байнгын гишүүн болсон 3 брокерын компани байна.

<b>Арилжааны дүн</b>	<b>450.3 тэрбум төгрөг</b>
<b>Гишүүний тоо</b>	<b>30</b>
<b>Итгэмжлэгдсэн агуулахын тоо</b>	<b>18</b>

#### Хүснэгт 1. Үйл ажиллагааны хураангуй

Гишүүн брокерын компаниудад болон шинээр биржийн гишүүн болох хүсэлтэй хувь хүн, хуулийн этгээдэд зориулан “Байнгын гишүүн брокерын мэргэшүүлэх сургалт”, “Брокерын эрх олгох сургалт” зэрэг сургалтуудыг шат дараатай зохион байгууллаа.

Түүнчлэн биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасны дагуу агуулахын итгэмжлэл хүссэн компанийн материалыг хүлээн авч, агуулахыг шалгаж, итгэмжлэлийн шалгуур хангасан агуулахуудад итгэмжлэл олгон ажиллаж байна.

Биржээр арилжих барааны чанар, стандартыг мөрдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотод байрлалтай ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн дэргэдэх агуулахад үйлдвэрийн дамжлага (угаах, самнах)-тай байх шаардлага тавьж, ноолуур самнадаг 8 үйлдвэртэй итгэмжлэлийн гэрээ, ноолуур угаадаг 8 үйлдвэртэй гэрээг тус тус байгуулан ажиллаж байна.

Цаашид үйлдвэрлэлийн хүчин чадал болон дотоодоос ажиллах хүч авч ажиллуулах шалгуур үзүүлэлтүүдийг тавин итгэмжлэгдсэн этгээдийн тоог нэмэх зорилготой байна. Биржийн арилжаанд оруулах бараа, түүхий эдийн мэдээллийг итгэмжлэгдсэн агуулахаас “Агуулахын бүртгэлийн программ”-аар дамжуулан авч, тухайн өдрийн үдээс өмнө байнга шалгаж, хяналт тавьж ажиллаж байна.

Биржийн төлбөр тооцооны хувьд одоогийн байдлаар ХААН банк болон Төрийн банкттай хамтран ажиллах гэрээ



**ХААН БАНК**

байгуулан ажиллаж,

төлбөр тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэн ажиллаж байна. Цаашлаад фьючерсийн арилжааг нэвтрүүлмэгц Биржийн үйл ажиллагаа өргөжих хэрээр бусад арилжааны банкуудтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.



Мөн Биржийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор телевиз, радио, сонин хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн байгууллагуудтай хамтран ажиллаж, биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг өөрийн вэб хуудас, facebook, twitter хуудсуудад хөтлөн явуулж байна.

<https://www.mce.mn>

<https://www.facebook.com/pages/Хөдөө-Аж-Ахуйн-Бирж>

<https://twitter.com/НААБирж>

Мэдээлэл, технологийн хувьд 2014 оны эхний хагас жилд Биржийн арилжааг онлайн хэлбэрт шилжүүлж арилжаанд оролцогчдыг өөрсдийн

ажлын байрнаас /оффис/ биржийн арилжаанд оролцох боломжийг хангах үүднээс тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Биржийн дотоод хяналт шалгалт нь биржийн үйл ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, албадын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих, мониторинг хийх, биржийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлээс урьдчилан зэрэг зорилгоор хийгддэг бөгөөд энэ хүрээнд дотооддоо болон харилцагч гишүүн байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

2014 оны эхний хагас жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн ажлыг тоймлон хүргэвэл:

🔗 **Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон түүнд холбогдох бусад дүрэм журмыг боловсруулж батлуулав.**

Биржийн ТУЗ-ийн 2014.03.17-ны өдрийн 04 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ыг батлан, тус журмын дагуу Клиринг, төлбөр тооцооны журам, Арилжааны журам, Хяналтын журам, Гишүүнчлэлийн

албаны үйл ажиллагааны журам зэрэг дүрэм журмуудыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа болж байна.


🔗 **Биржийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх гэрээний стандарт болон шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан батлав.**

“Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон холбогдох бусад дүрэм журам шинэчлэгдэн батлагдсантай

холбогдуулан дараах баримт бичгүүдийг боловсруулан батлаж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- “Ноолуурын үйлдвэрийн агуулах”-д тавигдах шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх бичиг баримт
- Орон нутгийн ноолуурын агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх бичиг баримт
- Ноолуурын спот гэрээний стандарт
- Байнгын гишүүний гэрээний маягт
- Байнгын гишүүнээр элсэхэд тавих шалгуур
- “Арилжааны жишиг үнийн аргачлал”
- Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх бичиг баримт
- Итгэмжлэгдсэн агуулах, итгэмжлэгдсэн тээвэрлэгчтэй байгуулах гэрээний маягт боловсруулсан,
- Итгэмжлэгдсэн агуулахын, итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагааны журам боловсруулсан,

#### 🔗 Биржээр арилжигдсан бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт олгох ажил



Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журмын дагуу нийт 696 ширхэг бараа, түүхий эдийн тодорхойлолтыг олгов.

График1. Тодорхойлолтын тоо /хагас жилээр/

#### 🔗 Фьючерсийн туршилтын арилжааг зохион байгуулав.

Фьючерсийн туршилтын арилжааг биржийн арилжааны танхимд 04 сарын 07-27-ны өдрүүдэд 09:30-10:30 цагийн хооронд амжилттай явуулав. Туршилтаар ямааны самнасан цагаан ноолуур, амьд, дунд зэргийн тарга хүчтэй хонины арилжаа явагдав.

“Сангийн яам”, “Эдийн засгийн хөгжлийн яам”, “Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам”-ны эрх бүхий албан тушаалтнуудад фьючерсийн арилжааг танилцуулах зорилгоор брокеруудыг өргөнөөр оролцуулж туршилтын арилжааг явуулав.

## Самнасан ноолуурын фьючерсийн туршилтын арилжаа




График 2. Самнасан цагаан 1-р зэргийн ноолуур




График 3. Самнасан цагаан 1-р зэргийн ноолуурын үнийн хэлбэлзэл

Хазайлтын хэмжээ: 0.0651

Санал болгох дэнчингийн хэмжээ: 19.532%

Самнасан ноолуурын 16,270 гэрээ 1,052,144 төгрөгийн жигнэсэн дундаж үнэтэйгээр арилжигдлаа. Нийт 1,683,945,000 төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд 14 брокер нийт 700 сая төгрөгийн дэнчин ашиглав<sup>1</sup>.

## Амьд хонины фьючерсийн туршилтын арилжаа




График 4. Амьд хонь

<sup>1</sup> Фьючерсийн туршилтын арилжааны үеэр брокеруудын ашигласан дэнчин болон гэрээний төлбөрийг программын түвшинд зохиомол өгөгдлөөр оруулсан болно.



дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Үүнд:

- Спот арилжааны арилжаалагч серверийн ажиллагааг онлайн арилжааны хэлбэрт шилжүүлж программын ажиллагааг туршиж нэвтрүүлэв.
- Спот арилжаанд оролцогчийн программын онлайн сервэрт холбогдож ажиллах хувилбарыг боловсруулж, туршин нэвтрүүлэв.
- Арилжаа удирдагч болон арилжаа хянагчийн программуудад нэмэлт өөрчлөлтүүд хийж туршиж нэвтрүүлэв.
- Фьючерсийн арилжааны системийг боловсруулж туршиж, сургалт судалгаанд ашиглав.
- Тайлан мэдээ хүлээн авах программд нэмэлт өөрчлөлтүүдийг тусган, нийт ажилтнууд, албадын үйл ажиллагааны тайланг серверт тогтмол хүлээн авч хэвшив.
- Биржийн мэдээлэл, цахим бичиг баримтын архивийн программын эхний хувилбарыг боловсруулж ажилд нэвтрүүлэв.
- Биржийн шинэ журмын дагуу агуулахад бараа бүртгэх, бүртгэсэн барааны шилжилт хөдөлгөөнийг тусгах программ боловсруулж, туршиж нэвтрүүлэв.
- Биржийн арилжаанд оролцогчийн оффисын программ боловсруулж, туршиж эхний хувилбарыг нэвтрүүлэв.
- Өгөгдөл, мэдээллийн сангийн дизайныг шинэчилж, программ хангамжуудад дизайны шинэчлэл, өөрчлөлтийг тусгаж нэвтрүүлэв.

☑ **Арилжаанд шинэ бүтээгдэхүүн оруулахтай холбоотой бэлтгэл ажлууд хийгдлээ.**

Биржийн арилжаанд оруулах шинэ тодорхойлолт боловсруулахтай бүтээгдэхүүний судалгаа, холбогдох холбоотой ажлууд хийгдэж байна. стандарт, мэдээллийг цуглуулах, Үүнд:

- Малыг фьючерс гэрээний арилжаанд оруулах барааны тодорхойлолт боловсруулав.
- Төмс, хүнсний ногоог арилжаанд оруулах боломжийг судалж, төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Цагаан будаа, элсэн чихрийг биржээр арилжих бололцоог судалж, импортын мэдээ, гадаад орнуудын биржийн арилжааны туршлага зэргийг судалж, боловсруулж байна.



☑ **Биржийн цахим хуудас болон e-mail сервэрүүдийн дизайн өөрчилж, шинэчлэлт хийх чиглэлээр хийгдсэн ажлууд**

Биржийн албан ёсны цахим байгууллагын e-мэйлийн үйлчилгээг хуудсанд өөрчлөлт оруулж мэдээ эрхлэх боломжийг судалж, сервэр мэдээлэл оруулах хэсгийг суурилуулж турших, харилцагч хэрэглэгчийн интерфэйсд шилжүүлэх байгууллагуудаас тохиролцсон болон арилжааны мэдээллийг хүснэгт форматын дагуу илгээсэн e-мэйлд болон график хосолсон хэлбэрт автомат шинжилгээ хийх, шилжүүлсэн эхний хувилбарыг харилцагчдад автоматаар e-мэйл ажиллууллаа. Одоогоор ашиглаж буй илгээх зэрэг программуудыг e-мэйл үйлчилгээг сайжруулан боловсруулж туршилт хийлээ. биржийн дотоод сервэр дээр

☑ **“Жишиг хоршоо” төсөл боловсруулахтай холбоотой ажлууд хийгдлээ.**

Биржийн 2014 оны төлөвлөгөөнд мэргэжил, аргагүйн зөвлөгөө өгч орсон “Жишиг хоршоо” төслийг ажиллаж байна. Холбогдох хууль боловсруулж, “Шинэ сум” төсөл тогтоомжийг судалж, төлөвлөгөө хэрэгжиж буй Баянхонгор аймгийн гарган ажиллаж, төслийн баримт Бууцагаан суманд хэрэгжүүлэх ажилд бичгээс гадна:

- дундын хоршооны дүрэм
- үйл ажиллагааны журам
- гишүүн хоршооны гэрээ
- дундын хоршооны ажлын байрны тодорхойлолт
- хөдөлмөрийн гэрээ
- татварын тооцоолол
- үүсгэн байгуулагчдын хурлын удирдамж зэрэг төслийн баримт бичигт зайлшгүй дагалдах баримт бичгүүдийг боловсруулж бэлтгэв.

Бууцагаан суманд удаа дараа томилолтоор ажиллаж, дундын хоршоо байрлан ажиллах ажлын байр, агуулахын төлөвлөлтийг хийж, сумын болон малчдын хоршоодын удирдлага, банкны салбарт төслийг танилцуулж, Улаанбаатар хотод болон орон нутагт нь сургалт явуулж бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллалаа.

☑ **Байнгын гишүүн оролцогчийн гэрээг шинэчлэн байгуулах**

Биржийн байнгын гишүүний гэрээ байгуулсан. Бусад брокерын шалгуур хангасан, гэрээний хугацаа компаниудын хувьд байнгын гишүүний дууссан 14 брокерын компанитай гэрээг шинэчлэн байгуулахаар бичиг “Байнгын гишүүний гэрээ”-г шинэчлэн баримтыг бүрдүүлж байна. байгуулсан ба шинээр 3 компанитай

### ☑ **Техник хангамжийн бүрдүүлэлтийн шинэчлэлттэй холбоотой хийгдсэн ажлууд**

Спот арилжааны онлайн хэлбэрт шилжих, фьючерсийн арилжааны онлайн системийг боловсруулж нэвтрүүлэх, байгууллагын оффис өөр байранд шилжсэн зэрэгтэй холбогдон байгууллагын дотоод болон гадаад холбоо интернэтийн сүлжээнд хийгдэх шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэсэн ба мөн сүлжээний болон бусад мэдээллийн технологийн өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэлээ. Биржийн мэдээллийн системд Линукс төрлийн үйлдлийн систем нэвтрүүлэх, NASDAQ-OMX группын системийг нэвтрүүлэхэд бэлтгэх зорилгоор Линукс үйлдлийн системийн Centos хувилбарыг сонгон e-мэйл сервер суурилуулж туршилт хийлээ.

### ☑ **Хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.**

Хөдөө аж ахуйн Бирж нь биржээр арилжиж байгаа бараа, итгэмжлэгдсэн лаборатори болон бүтээгдэхүүнийг хөндлөнгийн ХААИС-ийн дэргэдэх лабораторитой лабораториар шинжлүүлэн дүгнэлт хамтран ажиллах санамж бичиг гаргуулж байна. байгуулан, шаардлагатай тохиолдолд

### ☑ **Сургалт**

Зах зээлийн оролцогчид буюу сургалт, семинар, хэлэлцүүлгийг брокерын компаниудад зориулан шат зохион байгуулаад байна. Үүнд: дараатай, мэргэшүүлэх дараах

- Байнгын гишүүн оролцогч брокерын мэргэшүүлэх сургалт
- Арилжааны брокерын эрх олгох сургалт
- “Брокерын компанийн төлөвшил, хөгжлийн асуудал” сэдэвт сургалт
- “ХАА-н биржийн зах зээл ба арилжааны оролцогчид сэдэвт хэлэлцүүлэг” зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт “Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо”, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, ХАА-н Биржийн зохицуулах зөвлөлийн ажлын алба зэрэг байгууллагуудад хамтран оролцсон.

### ☑ **Эрсдэлийн удирдлагын багийн ажил**

Гүйцэтгэх захирлын тушаалаар түүний дагуу Биржийн үйл томилогдсон эрсдэлийн удирдлагын ажиллагаанд үүсч болох эрсдэлүүдийг багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн урьдчилан тодорхойлж холбогдох арга баталсан бөгөөд эрсдэлийн хэмжээнүүдийг авч ажиллаж байна. удирдлагын төлөвлөгөөг батлуулж

### ☑ Биржийн худалдан авалттай холбоотой ажлууд

ТӨХ-ноос батлагдсан зорилтот түвшний хүрээнд Биржийн 2014 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу гүйцэтгэж байна.

### ☑ Авлигын эсрэг үйл ажиллагаа

“Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтныг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, Биржийн эрх бүхий албан тушаалтнууд хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд нь

мэдүүлж, авлига болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудад сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулан, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтэнд нь хяналт тавьж, тайланг улирал улирлаар гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлж байна.

### ☑ Брокерын компанийн хөгжил, төлөвшил, гишүүнчлэлийг идэвхижүүлэх ажлын хүрээнд

Гишүүн брокеруудад зориулсан гарын авлага гаргаж хүргүүлэх, гишүүн брокеруудын ажлын байранд Back office программ суулгах/14 брокерын компанид суулгасан/ болон

гишүүнчлэлгүй зарим аймаг орон нутгийн холбогдох хүмүүстэй уулзаж, судалгаа хийж, гишүүн брокерын үйл ажиллагааны талаар танилцуулга хийж байна.

### ☑ Судалгааны ажлууд

Хөдөө аж ахуйн Биржийн үйл ажиллагаа өргөжиж биржээр зөвхөн спот арилжаа төдийгүй фьючерсийн арилжаа хийх бэлтгэж ажлууд хийгдэж байгаа, мөн цаашид зах зээлийн талаарх мэдээллийг нарийвчлан гаргах, бараа түүхий

эдийн бирж дээр арилжигдах шинэ бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлтэй холбоотой судалгааг хийхэд компанийн зүгээс анхаарч 2014 оны эхний хагас жилийн байдлаар дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Туршилтын арилжааны өгөгдөлд гэрээний нөлөөлөх үнэ, хөрвөх чадвар, эрсдэлийн судалгаа

- Биржээр арилжигдах боломжтой уул уурхай ашигт малтмалын судалгаа
- Олон улсын таваарын биржийн эрсдлийн удирдлага, дотоод хяналтын туршлагауд
- Олон улсын таваарын биржүүдийн эрсдлийн удирдлагын туршлага судлах судалгааны ажил
- Эрсдэлийн Удирдлагын аргачлал, эрсдлийг үнэлэх аргуудын судалгаа
- Линукс системд ажилладаг өгөгдлийн сангийн PostgreSQL болон Informix үйлдлийн системийн талаар судалгааны ажил

🔍 **Биржийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлууд:**

1. Олон улсын стандарт шаардлагад нийцсэн арилжаа, төлбөр тооцооны системийг худалдан авч суурилуулах, түүнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдэх.
2. Улаанбаатар хот болон орон нутаг дахь итгэмжлэгдсэн агуулах, тээврийн байгууллагын тоог нэмэгдүүлэх, логистикийн оновчтой системийг нэвтрүүлэх
3. Спот арилжааг онлайнаар явуулах, фьючерсийн арилжааг нэвтрүүлэх
4. Гишүүд, харилцагчдын үйл ажиллагааг хялбаршуулах, тэдэнд хурдан шуурхай үйлчлэх зорилгоор Биржээр арилжигдсан бараа, бүтээгдэхүүний тодорхойлолтыг цахим хэлбэрээр олгох
5. “Жишиг хоршоо” төслийн үйл ажиллагааг өргөжүүлэх

## АРИЛЖАА

2014 оны эхний хагас жилийн байдлаар нийт 99 удаагийн арилжаа явагдаж, биржийн арилжаагаар 5 төрлийн ноолуур, 4 төрлийн тэмээний ноос, 3 төрлийн хонины ноос, 2 төрлийн тосны ургамал болон ямаа, хонь, тэмээний завод ноос тус

тус арилжигдсан байна. Тайлант хугацаанд биржийн арилжааны өдрийн дундаж дүн 4.5 тэрбум төгрөг, нийт арилжааны дүн 450.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.4 дахин өссөн үзүүлэлт юм.




График 6. ХААБ-ийн арилжааны дүн /сая төгрөгөөр/

Эхний хагас жилийн байдлаар хамгийн өндөр дүнтэй арилжаа 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 18.2 тэрбум төгрөг байсан бол хамгийн бага дүнтэй арилжаа 2014 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 48.8 сая төгрөг байлаа. 2014 оны эхний хагас жилийн арилжааны дүнгээс харахад

ямааны ноолуур хамгийн их арилжигдсан байна.

Тайлант хугацаанд нийт 3192 тонн хонины ноос, 10284 тонн тосны ургамал, 1032.7 тонн ямааны завод ноос, 24 тонн тэмээний завод ноос, 670 тонн хонины завод ноос арилжлаа.




График 7. Нийт арилжигдсан барааны үнийн дүн /барааны бүлгээр/

Хөдөө аж ахуйн биржээр 2014.05.05-ны өдрөөс тэмээний *завод ноос*, 2014.05.09-ний өдрөөс хонины *завод ноос* анх удаа арилжигдаж эхэлсэн бөгөөд Биржээр арилжигдах ноосны төрлийн бүтээгдэхүүний хэмжээ ихэсч байгаа нь нэг талаас 2013 онд орон нутагт үндэсний үйлдвэрлэгчдийн зүгээс ноосны

урамшууллын падаан тараасан боловч уг падаанаар урамшууллаа бодуулах, авах нь он дамнаж, сунжирсан ажил болсон нь малчид, малтай иргэд бирж болон түүний брокеруудаар дамжуулан арилжаанд оролцох сонирхлыг нэмэгдүүлсэн гэж дүгнэж байна.

## Ноолуурын арилжаа

Тайлант хугацаанд бирж нийт 419.8 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 5287.6 тонн ноолуур арилжиж, 1 кг ноолуурын үнэ 75250 – 90000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

Ноолуурын үнэ 2013 онтой харьцуулахад өссөн байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл нөлөөлсөнтэй холбоотой.




График 8. Боловсруулаагүй ноолуурын дундаж үнийн харьцуулалт /төгрөгөөр/

### Боловсруулаагүй ноолуурын үнийн хэлбэлзэл

	Бараан ноолуур	Цайвар ноолуур
Дээд үнэ	90,000	90,000
Доод үнэ	75,250	76,890
Жигнэсэн дундаж үнэ	79,054	81,075

Хүснэгт 2. Боловсруулаагүй ноолуурын дундаж үнийн хэлбэлзэл /төгрөгөөр/

### Биржээр арилжигдсан ноолуурын хэмжээ




График 9. Арилжигдсан ноолуурын хэмжээ

## БИРЖИЙН БАЙНГЫН ГИШҮҮН ОРОЛЦОГЧ БРОКЕРЫН КОМПАНИУД

№	Компанийн нэр	Орон нутгийн харьяалал	Байнгын гишүүн оролцогчийн гэрээ байгуулсан огноо
1	Төв таван эрдэнэ (0036)	Төв	2014-05-09
2	Ханбүргэд хэнтий (0005)	Хэнтий	2014-05-16
3	Танан дээж трейд (0029)	Улаанбаатар	2014-05-16
4	Цэц-Инвест (0010)	Улаанбаатар	2014-05-16
5	Роял кашимер (0037)	Улаанбаатар	2014-05-20
6	Хаан тэлмэн (0008)	Улаанбаатар	2014-05-26
7	Увс таван эрдэнийн ундарга (0030)	Увс	2014-05-28
8	Баярплант (0015)	Улаанбаатар	2014-05-29
9	Ивээлт Инэл (0006)	Улаанбаатар	2014-05-29
10	Өвөр таван эрдэнийн шим (0022)	Өвөрхангай	2014-05-29
11	Стандарт таваар (0034)	Улаанбаатар	2014-05-29
12	Бадархундага оргил (0001)	Завхан	2014-05-30
13	Эрхэм сүрэг (0038)	Говь-Алтай	2014-06-06
14	Сантланс (0007)	Төв	2014-06-12
15	Алтан шагай импэкс (0031)	Улаанбаатар	2014-06-26
16	МЭТУ (0018)	Улаанбаатар	2014-06-17
17	Бурнавасан од (0023)	Өмнөговь	2014-06-25
18	Вүүдсоунд (0009)	Увс	2014-06-26
19	Хөвчийн тал (0004)	Дорнод	2013-05-02*
20	Өлгий түүхий эд (0011)	Баян-Өлгий	2013-05-06*
21	Саяанхаан (0013)	Булган	2013-04-30*
22	Бурхант таван эрдэнэ (0014)	Дархан	2013-06-24*
23	Батбилгэх (0016)	Дундговь	2013-05-02*
24	Гурван цаст гал тамга (0017)	Ховд	2013-05-13*
25	Мөрөн таван эрдэнэ (0020)	Хөвсгөл	2013-05-14*
26	Засагтхан гарьд (0021)	Завхан	2013-05-01*
27	Хонгорын таван эрдэнийн хишиг (0025)	Баянхонгор	2013-11-18*
28	Өлгий ундарга (0032)	Баян-Өлгий	2013-05-02*
29	Гүүдкомэкс (0033)	Улаанбаатар	2013-05-03*
30	Батсигнач (0035)	Улаанбаатар	2013-08-29*

Хүснэгт 3. Биржийн гишүүдийн жагсаалт.

Энд биржийн шинээр биржийн гишүүнчлэл олгосон брокерын компаниудыг тэмдэглэв.



“Хөдөө аж ахуйн бирж” ХХК  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж - 37, GB Plaza  
Утас: 7011-8779, 7012-8779, 7012-8775, 7012-8776, 7014-8779  
Факс: 7014-8779  
[www.mce.mn](http://www.mce.mn)

---